*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН МАГАДЛАГЧ ЭМЧ Б.ПҮРВЭЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Tetg<br>Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ НЭГ.**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**<br>**Эрүүл мэндийн байгууллагатай хамтран эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээг нэгдсэн бодлого зохицуулалттай явуулах.** | | | | | | |
| | *Арга хэмжээ 1.1.1.*<br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, шийдвэр гаралтанд оролцож, орон нутгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комисс, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг уялдуулах, хялбаршуулах | Холбогдох хууль, тогтоомж, шийвэрийг хэрэгжүүлэх | 2024 онд ЭММЗ 42 удаа хуралдаж 3190 иргэний асуудлыг шийдвэрлэсэн байна. | 2025 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 21 удаа хуралдаж 1501 иргэн /даатгуулагч/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны асуудлыг шийдвэрлэв. Энэ хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн бичиг баримтанд түүврийн аргаар дахин магадлалыг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2 магадлагч эмчийн бүрэлдхүүн ирж нийт 300 иргэнд хийлээ. Дахин магадлалаар 6 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг цуцалж 11 иргэний хувийг бууруулж, 5 иргэний хувийг нэмж, үлдсэн иргэдийнхийг хэвээр магалав. 2025 оны эхний хагас жилийн | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар эрүүл мэндийн магадлалын программд 3190 иргэний бүртгэл байна.ЭММЗ-ийн хурал болгоны дараа шинэчилсэн файль тавьж Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Улсын бүртгэлийн хэлтэсийн программтай тулгаж шалгадаг болсноор иргэний бүртгэлийн талаархи алдаагүй болов.<br><br>2025 эхний хагас жилд ЭММЗ-ийн хурлаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь. хугацаа шийдвэрлүүлсэн 1501 иргэдийн өвчний онош код, бичиг баримтын бүрдэлийн зөрүү 2024 оныхоос даруй 2.5 дахин буурч 12 бүртгэгдлээ. Мөн иргэн /даатгуулагч/-ыг хуралд өөрийн биеэр заавал ирүүлэхгүй байх журам 98.2 %-тай хэрэгжиж байна. Шаардлагатай үед иргэн /даатгуулагч/-ыг биеэр ирүүлж асуудлыг шийдвэрлэж байна. ЭММЗ-ийн хурал бүрд видео-камер ажиллуулж бичлэг хийдэг ба хурлын дараа бичлэг болон хурлын файлаа Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлрүү илгэээдэг. Энэ нь хурлын үйл явцыг төв зөвлөл бүрэн хянах, мөн хурлын дараа гомдол, санал гарахад эргэж тухайн асуудлыг шүүж үзэх зэрэгт ач холбогдолтой боллоо. Яг одоогоор видео камерийн багтаамжийг шалгуулж засвар хийгдэж байна.<br><br>Мөн иргэн /даатгуулагч/-ын асуудал хурлаар шийдэгдсэний дараа ажлын 8 цагт багтан тэтгэмж нь шууд дансанд нь орж байна.. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Арга хэмжээ 1.1.2.*<br><br>Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийж, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурал болгонд иргэн даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллах мөн эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас олголттой холбоотой санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх | Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн зорилго зорилт | 2024 онд 2 удаа судалгааны ажил, 318 иргэнээс сэтгэл ханамжийн асуулга , 8 иргэний өргөдөл гомдол шийдвэрлэх ажил хийгдсэн | Иргэн /даатгуулагчид/-ыг ЭММЗ-ийн хурал, ирүүлэхгүй болсонтой холбогдуулан сэтгэл ханам үр дүнг тооцож ажиллах боломжгүй болсон Гэх үед дуудагдсан иргэдээс дээрхи судалгааг авч хагас жилд 1501 иргэний 10 % буюу 150 иргэнийг, ба сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгэ Эмнэлгийн хуудас олголттой холбоотой 51 санал 98 иргэний эмнэлгийн хуудсын үндэслэлийг шийдвэрлэв. Биелэлтийн хувь | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| | *Арга хэмжээ 1.1.3*<br><br>Орхон аймгийн хэмжээнд байгаа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэн /даатгуулагч/-ын материалд түүврийн аргаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, ижил мэргэжилтэний үзлэг зохион байгуулах | Орон нутгийн удирдлага болон НДГ-тай хамтран хамтарсан болон дахин магадлалын бэлтгэл ажлыг хангасан байна | 2024 онд 200 иргэнд түүврийн аргаар, ЭММТЗ"тэй хамтран 1 удаа 840 иргэнд дахин магадлал хийгдсэн | 2025 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хянах, туршлага солилцох зорилгоор ижил мэргэжилтний үзлэгийг 1 удаа , 3 дугаар сард Бусийн оношлогоо эмчилгээний төв болон Багануур дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн эмч нартай хамтран 60 иргэн даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны талаар ижил мэргэжилтний магадлалыг зохион байгуулсан байна. 2025 оны 4 дүгээр сард Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 300 иргэнд түүврийн аргаар дахин магадлал хийлээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

148

| 2.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД<br>Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг хангах ажиллах | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Арга хэмжээ .2.1.1*<br><br>Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомж, шинэ дүрэм, өвчний ангилал, жагсаалтыг мөрдөж ажиллах | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Эрүүл мэндийн сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан А/177, А/433 тоот тушаал, Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоол | | 2025 оны эхний хагас жилд ЭММЗ нь нийт 21 удаа хуралдаж нийт 1501 иргэний ХЧА-ын асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:<br>➢ Хөдөлмөрийн нөхцөл сольсон - 1<br>➢ ХЧТА-ын хувийг нэмэгдүүлж сунгасан- 11<br>➢ ХЧТА-ын хувийг бууруулж сунгасан – 35<br>➢ ХЧТА-ын хувийг хэвээр сунгасан - 1412<br>➢ ХЧТА-ын хувь, хугацааг цуцалсан - 115<br>➢ Шинээр ХЧА-ын хувь тогтоосон – 75<br>➢ Шилжиж ирсэн -10<br>➢ Шилжиж явсан -11<br>➢ Тайлант хугацаанд ХЧА иргэн нас барсан – 35<br>Хурлын явцад ХЧА-ын хувь тогтоолгосон даатгуулагчдын эмнэлгийн хувийн хэргийг комиссын программтай тулгаж өвчний заалт, онош тохирсон байдал өвчний хүндрэл болон хавсарсан өвчнийг давхар бичих, хувь нэмэгдсэн болон хасагдсан тохиолдлуудыг хувийн хэрэгт тэмдэглэж хэвшлээ. ХЧА-ын сунгалтын үргэлжлэх хугацаа, тогтоосон, сунгасан он сар өдрийг программтай нэг бүрчлэн тулгаж бичилтийг шалгаж иргэдэд чирэгдэлгүй ажиллаж байна. ЭММЗ-ийн хурлыг долоо хоног бүрийн Пүрэв гаригт тасралтгүй 80-100 хувийн ирцийн бүртгэлтэй хуралдуулж шийдвэрт зөвлөлийн гишүүдийн гарын үсэг бүрэн эсэхийг шалгаж хурлын төгсгөлд цагийн мэдээ, хуралд орсон иргэн /даатгуулагч/-ийн нэрсийн жагсаалт, протоколоор баталгаажуулан ажиллалаа. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| | *Арга хэмжээ .2.1,2* | Эрүүл мэндийн | 2024 онд төрөлжсөн | 2024 оны 1 сард Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн | | |

194

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүтэн болон хагас жил тутамд ЭММЗ-ийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах | магадлалын зөвлөлийн дүрэм | мэргэжлийн эмч нарын сургалтыг цахимаар 2, семинараар 1 удаа хийсэн | сонгон шалгаруулалтыг Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж бүрэлдхүүнийг шинэчилсэн бөгөөд зөвлөлийг хувийн хэвшлийн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал эмнэлэг зэрэг байгууллагын оролцоог хангаж байгуулаад ажиллаж байна.<br><br>ЭММЗ-ийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын сургалтыг цахим /зоом/, семинар, танхимаар 2025 оны эхний хагас жилд 4 удаа зохион байгуулжээ. Мөн дахин магадлалын дараа оношлогоо шинжилгээний талаархи гарын авлагыг 9 өрхийн эмч болон зөвлөлд хүлээлгэн өгсөн.<br><br>Биелэлтийн хувь 100% | 2025.01.01 2025.06.10 | 100% |
| Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлах чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ | | | | | | |
| | *Арга хэмжээ .2.3*<br><br>Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц | 2024 онд хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх сургалт 21 ААНБ-д 8 удаа, аймгийн ХАБЭАЗ-өөс 1 удаа сарын аян хийсэн | Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм батлагдсан ба үүнтэй холбоотойгоор эрүүл мэндийн магадлалын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны жагсаалт шинэчлэгдэн гарсан.Энэ бүхний талаар 9 Өрхийн эрүүл мэндийн төв болон Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн амбулаторийн эмч нарт 1 удаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 тоот тушаалаар батлагдсан даатгуулагч иргэний эмнэлгийн | 2025.01.01 2025.06.10 | 100% |

141

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хууль, Эрүүл мэндийн сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан А/177, А/433 тоот тушаал, Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоол | | хуудас олгох журмын талаар 9 Өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, 12 хувийн хэвшлийн эмнэлэг, Эрдэнэт-медикал эмнэлэг, Эрдэнэт-сувилал, Жаргалант сумын эрүүл мэндийн төв зэрэг газруудад нийт 3 удаагийн сургалт зохион байгууллаа. Мөн манай Нийгмийн даатгалын газрын Орхон ндаатгал.мн. сайтаар тогтмол мэдээ, мэдээлэл өгч байгаа ба өнөөдрийн байдлаар 21737 дагагчтай байна.<br><br>2025 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд Нийгмийн даатгалын газраас 1 удаа, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2 удаа, Нийгмийн даатгалын ерөнхий газар, авлигатай тэмцэх газраас хамтран 1 удаа авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зоом болон танхимаар тус тус сургалт зохион байгууллаа. 2025 оны 1 дүгээр сард ЭММЗ-ийн төрөлжсөн мэргэжлийн эмч нартай гэрээ байгуулж авлига, ашиг сонирхлын ,ёс зүй хэм хэмжээний талаар заалт оруулла. 2020 оноос хойш 5 жилийн хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь. хугацааны жагсаалтанд байгаа иргэдийн тоо 13%-иар буурсан байна Өнөөдөр улсын дундаж 2.9 % бол Орхон аймгийнх 2.9 % | | |
| | <u>*Арга хэмжээ 2.4*</u><br><br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах, таниулж | Аймаг сумдын ЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс, | 2024 онд Өрхийн эрүүл мэндийн удирдлага, эмч, Эрүүл | Иргэн /даатгуулагч/-ын дунд Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон Эмнэлэг хяналтын комисс, ХХҮГ-ын халамжийн хурал, Эмнэлэг хяналтын комиссын асаргааны хурал Мэргэжлээс шалтгаалах өвчний хувь, хугацаа тогтоох хурлуудыг хооронд нь эндүүрэх, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тайлбарлах цуврал уулзалт, ярилцлага хийх, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх чиглэлээр сургалтыг зохион байгуулах | Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн төрөлжсөн мэргэжлийн эмч, удирдлага, Өрхийн эрүүл мэндийн удирдлага, эмч, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хамтын үйл ажиллагааг уялдуулах | мэндийн газар, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд цахим , семинараар 2 удаа авлига ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх сургалтыг зохиож ,аймгийн удирдлагын түвшинд 1 удаа уулзалт хийсэн | шийдвэрийг нь ялгахгүй байх, үйл ажиллагаанд нь өгсөн дүгнэлтээ андуурч мэдээлэх зэрэгт дүгнэлт хийж ЭММЗ-ийн хурлын үеэр иргэн /даатгуулагч/-дад ухуулан таниулах материал тараах, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд иргэнээ танилцуулдаг амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн болон өрхийн эмч нарт мөн аймаг, сумын удирдлага, Эрүүл мэндийн газарт Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар танилцуулга тайлангаа тавьж ирлээ. 2025 онд Аймгийн засаг даргатай уулзаж ЭММЗ-д шаардлагатай байгаа тоног төхөөрөмж хөрөнгө оруулалтын саналаа хүргүүллээ Түүнчлэн ЭММЗ-ийн хурлын цагт камер ажиллуулж хурлын явцын бичлэгээ эрүүл мэндийн магадлах төв зөвлөлд тогтмол явуулж байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 90% |
| | <u>*Арга хэмжээ 2.5*</u><br><br>Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх | Цахим мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж нууцлалын найдвартай байдлыг хангаж хяналт тавьж ажилласан байх | 2024 онд программын өөрчлөлтөөр 1200 иргэний мэдээлэл хувь, хугацааны сунгалтын он, сар өдрөөс хамааран шинэчлэгдсэн | 2025 оны эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн магадлалын программд 3190 иргэний бүртгэл байна. 2024 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны жагсаалт шинэчлэгдсэнтэй холбоотой программд орох өөрчлөлтийг хийж байна.Энэ нь иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны сунгалт ,цуцлалт хийхтэй давхцдаг учир 70 %-тай явагдаж байна.<br>ЭММЗ-ийн хурал болгоны дараа шинэчилсэн файл тавьж Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Улсын бүртгэлийн | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлтэсийн программтай тулгаж шалгадаг болсноор иргэний бүртгэлийн талаархи алдаагүй болов | | |
| Эрүүл мэнд, эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ | | | | | | |
| | *Арга хэмжээ 2.6*<br><br>Эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудасны бичилтэнд, иргэн сайн дурын даатгуулагч болон ААН байгууллагын ажилчидын хөдөлмөрийн чадвар түр алдсан , жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг хянах | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/443 дугаар тушаал | 2024 онд нийт хуудасны 15 %-ийг түүврээр үндэслэлийг нь шалгасан ба 10000 ХЧА болон ЖА- ны хуудас хянажээ | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 тоот тушаалаар батлагдсан даатгуулагч иргэний эмнэлгийн хуудас олгох журмын талаар 9 Өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, 12 хувийн хэвшлийн эмнэлэг, Эрдэнэт-медикал эмнэлэг, Эрдэнэт-сувилал, Жаргалант сумын эрүүл мэндийн төв зэрэг газруудад нийт 3 удаагийн сургалт зохион байгуулж цахим эмнэлгийн хуудас бичих программаар 2024оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн хангагдлаа. Өнөөдрийн байдлаар. гадны аймаг сумдаас хаа нэг бичмэл эмнэлгийн хуудас ирж байгаа ч эмнэлгийн хуудсыг аймгийн хэмжээнд 100 % цахимаар бичиж байна. 2025 оны эхний хагас жилд ХЧТА 4993, 795 ЖА эмнэлгийн хуудас хянаж, 114 ЖА эмнэлгийн хуудас харьяалалын дагуу буцааж, 417 ХЧТА эмнэлгийн хуудас цуцалж, магадлан итгэмжлэгдсэн 4 сувилалд 115 иргэн амрааснаас 4 иргэний эрх цуцлагджээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Арга хэмжээ 2.7*<br><br>Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудасны бичилт олголттой холбоотой санал гомдол, албан бичиг өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх | Иргэдийн өргөдөл гомдол хүлээн авах шийдвэрлэх хууль дүрэм, журмын хүрээнд өргөдөл, гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх | 2024 онд иргэдээс ЭММТЗ-д 1 өргөдөл, НДЕГ-т 1, НДГ-т 4 өргөдөл ирснийг шийдвэрлэжээ | 2025 оны эхний хагас жилийн байдлаар сайн дурын даатгуулагч болон ААН байгууллагын 4993 эмнэлгийн хуудас, жирэмсэн, амаржсаны 795 хуудас хянаж баталгаажуулав. 2024онд эмнэлгийн хуудас бичих эрх бүхий байгууллагуудаас түүврийн аргаар 101 үндэслэл тодорхойлохоор 502 нийтдээ 603 эмнэлгийн хуудсанд хяналт шалгалт хийлээ.Шалгалтаар эмчийн буруу бичилттэй /үг, үсгийн алдаа, регистр, овог нэр зөрүүтэй, ажиллаж байгаа газрын хаяг буруу/ 14, үзлэгийн журнал, цаг авалтгүй бичсэн 1, иргэнээс шалтгаалж хүчингүй болсон 417 эмнэлгийн хуудас гарсныг цуцалж бусад шалтгааныг 2022.09.20 өдрийн 01/1657 тоотоор,мөн А/177, А/433 тоот журмын заалтын дагуу засаж залруулжээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| | *Арга хэмжээ 2.8*<br><br>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хиймэл эрхтэн ,засал эмчилгээний тусламж үйлчилгээ болон сувилалын үйлчилгээ, Эрдэнэт-сувилал цогцолбор, НДГ-ын хамтын ажиллагааны гэрээнд хяналт тавьж, улирал бүр Эрдэнэт-сувилал цогцолборын үйл ажиллагаатай биечлэн танилцах | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон шийдвэр, үйлдэрлэлийн ослын акт, сувиллын тусламж үйлчилгээний чанарыг дүгнэн холбогдох арга хэмжээ авч ажиллах, Эрдэнэт-сувилал цогцолбор, НДГ-ын 2025 | 2024 онд Эрдэнэт-сувилал цогцолборын үйл ажиллагаатай 2 удаа биечлэн танилцаж заавар зөвлөгөө өгсөн | Эрдэнэт-сувилал цогцолбор, НДГ-ын 2025 оны НД/11/25 тоот гэрээний дагуу магадлагч эмч улиралд 1 удаа Эрдэнэт-сувилал цогцолборын сэргэн засах тусламж үйлчилгээний үйл ажиллагааг хянаж шалган заавар зөвлөмж өгч ажиллав. Сувилуулж буй 45 иргэнээс биеэр, сувилуулаад гарсан 50 иргэнээс утсаар сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллаа.Мөн ХХҮГ-ын эрх үүсээгүй албан тоотыг хиймэл шүдээр 5, протезоор 2 иргэнд хийж өглөө. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

119

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | оны нд/11/25 тоот гэрээ | | | | |
| | *Арга хэмжээ 2.9*<br>Өөрийн хариуцсан ажил үүрэгтэй холбоотой сургалт мэдээллийг газрын албан хаагчдад эмнэлгийн хуудас олголттой холбоотой сургалт мэдээллийг эрүүл мэндийн магадлалын эмч нартай хамтран эрүүл мэндийн байгууллагын эмч нарт хийх, зөвлөгөө мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах, үр дүнг тооцох | Мэдээллийн урсгал сайжирсан байх, сургалт орсон байх, сургалтын төлөвлөгөө гаргасан байх | 2024 онд 9 ӨЭМТ, 11 хувийн хэвшлийн эмнэлэг, өөрийн байгууллага, ЭММЗ-д нийт 4 удаа сургалт орсон | 2025 оны эхний хагас жилд эмнэлгийн хуудас олголттой холбоотой сургалт мэдээллийг 9 ӨЭМТ 12 хувийн хэвшлийн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал, Эрдэнэт-сувилал цогцолбор, Жаргалант ЭМТ-д 13 удаа өгч өөрийн гар утсаар хугацаа харгалзахгүй мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаа.Мөн 5 дугаар сард байгууллагын ФБ хуудас, шууд лайваар хөдөлмөрийн чадвар алдалт, эмнэлгийн хуудас, жирэмсэн амаржсаны тэтгэмжийн талаар мэдээлэл өгч иргэн /даатгуулагч/-дын сонирхсон асуултанд хариуллаа. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| | *Арга хэмжээ 2.10*<br>ЭММЗ-ийн хурлын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хурлын нөөтбүк, хэвлэгчийг шинэчлэх, сургалтын LED самбар авах | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан ЭММЗ-ийн дүрмийн 8 дугаар бүлэг | 2024 онд хурлын хэрэгцээнд ус буцалгагч, сандал зэрэг 5,0 сая төгрөгний асуудал шийдвэрлүүл-сэн | Хурлын хэрэгцээнд нөөтбүк DELL core i9 – 3,5 сая, хэвлэгч SAMSUNG- 1,2 сая, сургалтын LED самбар 5.8 сая төгрөг бүхий төсөв аймгийн даргаар батлуулж шийдвэрлүүлэхээр хандсан Эхний хагас жилд төсвийн тодолголоор батална | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| **3.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Арга хэмжээ .3.1*<br><br>Нийгмийн даатгалын байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй “ISO 37001:2016, ISO 9001:2015 стандартын нэгдсэн менежментийн тогтолцоо”-г үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, тасралтгүй сайжруулалт хөгжүүлэлтийг тогтмол хийж санаачлагатай ажиллах | -Стандартыг мөрдөж ажилласан тухай ажлын тайлан, гүйцэтгэл<br><br>-Санаачлан хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, чанар | | Нэгдсэн менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж тасралтгүй сайжруулалт хөгжүүлэлтийг тогтмол хийж санаачлагатай ажиллаа.<br>ЭММЗ-н хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор аймгийн засаг даргаар 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлуулсан.<br>Байгууллагын Эцэг, эхийн зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлд ажиллаж зохион байгуулсан ажлуудад идэвхитэй оролцож ирлээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| | *Арга хэмжээ 3.2*<br><br>“Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын өр барагдуулах нэрэмжит жил”-ийн ажлын хүрээнд хуваарь, төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэх | Санаачлан хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, ажлын гүйцэтгэлийн хувь | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх” 2024 оны нэрэмжит жилд багаараа тэргүүн байрт шалгарсан. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэн /даатгуулагч/-ын өндөр насны тэтгэврийг тооцуулж тэтгэвэрт гартлаа шимтгэл төлж байхыг зааварчилж 2025 оны эхний хагас жилд 21 иргэн тэтгэврээ тогтоолголоо. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | *Арга хэмжээ 3.3*<br><br>Өөрийн хариуцсан ажил үүрэгтэй холбоотой сургалт, сурталчилгаа хийх, шууд бичлэгт оролцох, пост постер контентын шинэ санал санаачлага гаргах, бусад байцаагч ажилтнуудад мэдээлэл солилцох дотоодын сургалт хийх | Сургалт, сурталчилгаа мэдээлэл хийсэн тоо Хамрагдсан албан хаагчийн тоо<br><br>Сургалтын тайлан | 2024 онд хяналтын болон хамралт орлогын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн байгууллага, ААН-д 2 удаа сургалт хийсэн | 2025 оны эхний хагас жилд Нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх зорилгын хүрээнд хариуцсан ажил үүрэгтэй холбоотой сургалт, сурталчилгаа хийж, байгууллагын шууд бичлэг болон лайвт ирсэн санал асуулгад тогтмол хариулж ирлээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 90 % |
| | *Арга хэмжээ 3.4*<br><br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, баримт бичгийг стандартын дагуу боловсруулах, архивын материалыг хуваарьт заасан хугацаанд архивт бүрэн хүлээлгэн өгөх | Баримт бичгийг стандартын дагуу боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэх<br><br>Архивын баримтыг хугацаанд нь өгсөн байдал<br><br>Хүлээлгэн өгсөн баримтын | 2024 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 1 баримт ЭММЗ-ийн 41 хурлын материалыг архивт хүлээлгэн өгсөн | ЭММЗ нь жилд 2 удаа архивт материалаа хүлээлгэн өгдөг ба архивын материал хүлээлгэн өгөх журмыг чанд баримталдаг болно<br><br>Түүнчлэн хурал болгоны дараа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа цуцлагдсан иргэний эмнэлгийн хувийн хэрэг болон актыг архивт, сунгасан тогтоосон иргэний материал, актыг тэтгэврийн байцаагчид хүлээлгэн өгч байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоо, гүйцэтгэлийн чанар | | | | |
| | *Арга хэмжээ 3.5*<br><br>Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7,8 дугаар зүйл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7, 8 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ" гэх мэт хууль дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авилга, ашиг сонирхолын зөрчилийн талаарх мэдээллийг нэн даруй холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээллэх. | Иргэдээс ирүүлсэн мэдээлэл өргөдөл, гомдлын тоо | 2024 онд Ёс зүйн хороонд 1 иргэнээс өргөдөл гомдол ирснийг хороо хянан хэлэлцээд ёс зүйн зөрчил биш гэж дүгнэсэн | 2025 оны эхний хагас жилд Хууль эрх зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллаа.<br>Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "ЁС ЗҮЙГЭЭРЭЭ МАНЛАЙЛЪЯ" уралдаант тэмцээнд идэвхи санаачлагатай рийл, постерны санааг гаргаж идэвхи санаачлагатай оролцсон.<br>"Бид соёлыг бүтээнэ, бид соёлыг түгээнэ" Нөлөөллийн арга хэмжээнд :<br>Ø 1 рийл<br>Ø 1 Хөгжөөнт тоглоом<br>Ø 3 постер | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

**Хоёр. МЭДЛЭГ УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | |
|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| | 2 | | 3 | 4 |
| | *Арга хэмжээ 1*<br><br>Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо,<br><br>Шалгалтын оноо | Монгол бичгийн цагаан толгойг бүрэн нүдэлж сурна | Монгол бичгийн анхан шатны......цагийн сургалтанд сууж монгол бичгийн цагаан толгойг бүрэн нүдэлж сурсан.<br><br>Биелэлтийн хувь 100% |
| | *Арга хэмжээ 2*<br><br>ЭММЗ-ийн мэргэжлийн чиг баримжааны сертификаттай сургалтанд суух | ЭММТЗ болон байгууллагын зохион байгуулсан сургалт | ЭММЗ-ийн хурлаар орж буй иргэн даатгуулагчийн гар карт, бүх төрлийн шинжилгээг иж бүрэн тайлж уншдаг болох | 2025 оны эхний хагас жилд ЭММТЗ-өөс ЗООМ сургалтыг 3 удаа явуулсан нь зонхилон тохиолдох 5 өвчлөлийн шинжилгээ, оношлогоо, харьцуулалтын хичээл байлаа. Эхний хагас жилд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, онош, шинжилгээ, үзлэгийн талаар 61 иргэнд зөвлөгөө заавар өгсөн байна.ТОП-5 өвчний жагсаалтад нүдний өвчлөл орж байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод нүдний төрөлжсөн 5 эмнэлэг дээр магадлагч эмч нарын 4 хоногийн практик сургалт болж сертификат олголоо<br>.<br>Биелэлтийн хувь 100% |
| | *Арга хэмжээ 3*Мэдээллийн технологийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах | Сургалтын гэрчилгээ батламж | | EXCEL программыг Ү.Мягмарсүрэнгийн удирдлаган дор суралцаж байна<br><br>Биелэлтийн хувь 100% |
| | *Арга хэмжээ 4*<br><br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдхүүн бусад 1-2 аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор | 2024 онд Булган аймгийн ЭММЗ-ийн үйл ажиллагаатай танилцсан | .<br><br>Аймгийн засаг даргад Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын талаар санал, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажиллагаатай танилцаж туршлага судлах | батлагдсан ЭММЗ-ийн дүрэм | | төсөв хүргүүлсэн бөгөөд 6 дугаар сард төсвийн тодотголоор батална.<br><br>Биелэлтийн хувь 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

МАГАДЛАГЧ ЭМЧ Б.ПҮРВЭЭ /........................../ 2025.06.05.